

Mongolian

Та мэдэх үү?

Тэмбүү хэнийг ч ялгахгүй халдварладаг ноцтой халдвар юм.



Тэмбүү нь бэлгийн замаар дамжих ноцтой халдвар /БЗДХ/
бөгөөд бэлгийн хавьтлын үеэр халдвартай хүнээс нөгөөд халдварлана.



Танд ямар ч шинж тэмдэг илрэхгүй байж болно

Зарим хүмүүс ямар ч зовиургүй, халдвар авснаа мэдэлгүй явах тохиолдол байдаг.

Тиймээс яр шархлаа гарч эхлэх, тууралт үүсэх, булчин үе мөч өвдөж хөндүүрлэх, толгой өвдөх, ядарч сульдах зэрэг шинж илэрч байгаа эсэхийг анхаараарай.



Шинжилгээ тогтмол өгөөрэй

Эмч болон эрүүл мэндийн төвд хандан, тэмбүүгийн сорилыг агуулсан БЗДХ-ын бүрэн шинжилгээнд хамрагдаарай.

Хэрэв та бэлгэвчгүйгээр секс, аман секс хийсэн бол БЗДХ-ын шинжилгээ өгөөрэй. Шинжилгээ өгөхөд ичих зүйл үгүй.



Эмчилгээ

Тэмбүүг эмчлэх хялбар – тохирох эмийн бэлдмэлийг хэрэглэхэд халдвар устана. Бэлгийн хамтрагчдаа мэдээллэснээр, тэд ч мөн шинжилгээ өгч, эмчилгээ хийлгэх ач холбогдолтой. Ингэснээр тэмбүүгийн халдварыг бусдад болон танд буцаан халдахаас сэргийлнэ.



Урьдчилан сэргийлэх

Аюулгүй бэлгийн харилцааг эрхэмлэх - үргэлж бэлгэвч хэрэглэх ба чийгшүүлэгч/лубрикант ашиглахдаа усан болон силикон суурьтайг сонгон хэрэглэх.

Хэрэв бэлгийн хамтрагчтайгаа холбоо барин, энэ талаар мэдээлэхэд таагүй байгаа бол www.letthemknow.org.au вэбсайт руу хандан зөвлөгөө авах юмуу GP эмч болон бусад эрүүл мэндийн ажилчидтай ярилцаарай.



Мэргэшсэн сувилагчтай ярихыг хүсвэл

1800 451 624 дугаараар Sexual Health Info Line (SHIL) (Бэлгийн Эрүүл Мэндийн Мэдээллийн Шугам).
Даваа – Баасан 09:00 - 5:30 цагийн хооронд.

131 450 руу залгаж орчуулагчтай холбогдон, төрөлх хэлээрээ ярилцаарай.

Жилийн бүх өдрүүдэд, 24 цагийн турш нээлттэй.
www.shil.nsw.gov.au вэбсайтаар зочлоорой



QR кодыг уншуулж
тэмбүүгийн талаар
дэлгэрэнгүй мэдээлэл
аваарай.